



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 02 дугаар  
сарын 23-ны өдөр.

Дугаар А.НБ

Улаанбаатар  
хот.

Боловсролын төв байгуулах  
тухай


1. Орон нутагт боловсролын хэргийг мэргэжлийн ба арга зүйн удирдлагаар хангах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх ажлыг сайжруулах зорилгоор Боловсролын газрын дэргэдэх судалгаа арга зүйн төвийг "Боловсролын төв" болгон, түүний бүтэц зохион байгуулалт, орон тоог I хавсралтад заасны дагуу баталж ШУБЯ-ны 1994 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн 59 тоот тушаалаар батлагдсан боловсрол төвийн үлгэрчилсэн дүрмийн дагуу зохион байгуулалтыг Боловсролын газар /Ц.Дорж/-т, батлагдсан орон тоог үндэслэн санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/-т тус тус үүрэг болгосугай.

2. Мэргэжлийн оношлогоо, зөвлөлгөө өгөх төвийг 1995 оны 3 дугаар сарын I-нээр тасалбар болгон татан буулгаж орон тоог гүйцэтгэж байсан үүргийн хамт Боловсролын газрын мэдэлд шилжүүлсүгэй.

3. Мэргэжлийн оношлогоо, зөвлөлгөө өгөх төвийн эзэмшиж байсан II хавсралтанд дурдсан 512,3 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг Боловсролын газрын балансад шилжүүлэхийг нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Болдсайхан/-т даалгасугай.

4. Хотын Боловсролын газрын дэргэдэх Боловсролын төвийн захирал н.Туул нь 1995 оны 2 дугаар сарын 16-наас жирэмсний амралт авсан тул Боловсролын төвийн санхүүгийн баримтанд I гарын үсэг зурж байхыг Боловсролын газрын дарга /Ц.Дорж/-д зөвшөөрсүгэй.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 1994 оны 3 дугаар сарын 4-ны өдрийн А/27 тоот захирамжийг хүчингүйд болгосон тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

*Ц.Баасанжав*

Ц.БААСАНЖАВ




Нийслэлийн Засаг даргын 1995  
оны 4-15 тоо захирамжийн  
1 дүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОУН БОЛОВСРОЛ ТӨВИЙН  
ОРОН ТОО  
У.Б. 11

Ажил мэргэжлийн нэр	Ажиллах орон тоо
I.Боловсрол төвийн захирал	I
2.Эрдэм шинжилгээний ажилтан	-
3.Арга зүйч	II
-математик	I
-Физик мэдээлэл зүй	I
-бага анги	I
-МОНГОЛ ХЭЛ, уран зохиол	I
-ТҮҮХ, НИЙГЭМ	I
-НОМЫН САНГИЙН АРГА ЗҮЙЧ	-
-ХИМИ БОИЛОГИ	I
-дуу хөгжим	I
-зураг хөдөлмөр	I
-СӨНХ	I
-Гадаад хэл	I
-Биеийн тамир-эрүүл мэнд	I
-Хумуужил хариуцсан арга зүйч	
-Албан бус сургалт хариуцсан арга зүйч	
-Тасралтгүй боловсрол хариуцсан	
арга зүйч	
-Мэргэжлийн оношлогооны мэргэжилтэн	I
4.Нягтлан бодогч	I
5.Нярав	I
6.Жижүүр	3
7.Слесарь	3
8.Үйлчлэгч	3
9.Бичээч	I
10.Номын санч	I
БҮГД	26





Нийслэлийн Засаг даргын 1995  
ОНЫ 2-р дугаар хавсралт

МЭРТЭЖЛИЙН ОНОШЛОГОО ЗӨВЛӨЛТӨӨ ӨГӨХ  
ТӨВӨӨС НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭР-  
ГЭДЭХ БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	нэг бүрийн үнэ	НИЙТ ҮНЭ
1.	Компьютер	1 ком	380000	380000
2.	Сейф /дунд зэргийн/	1 ш	21700	21700
3.	Сейф /жижиг/	1 ш	16000	16000
4.	Ширээ /2 шургуулгатай/	2 ш	14000	28000
5.	Ширээ /1 шургуулгатай/	2 ш	12100	24200
6.	Сандал	10 ш	2640	26400
7.	Бичгийн машин	1ш	16000	16000
	БҮГД			512300